



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2012 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/107

Мандалговь

Эзэмшил газрын хэмжээг өөрчлөх, зарим
хэсгийг нийтийн эзэмшилд шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, 39 дугаар зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Бага тойруу-3-10) хаягт байршилтай иргэн Дашнамжил овогтой Баттөгс (ЗИ:74021535)-ийн орон сууцны зориулалттай 1089 м.кв (0,1га) эзэмшил газраас (Бага тойруу-3-310) 514 м² (0,05 га) газарт 25-н айлын нийтийн орон сууц барьсан тул газрыг нийтийн эзэмшилд шилжүүлж, үлдсэн (Бага тойруу-3-312) тоот хаягт байршилтай 575м² (0,05га) газрыг иргэн Дашнамжил овогтой Баттөгсөд орон сууцны зориулалтаар 22 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж Аймгийн Засаг даргын 2012 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/322 тоот захирамжийн Д.Баттөгсөд холбогдох хэсэг, мөн газар эзэмших 0391605 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010:40